

**ГАЗРЫН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ, ШАТАХУУН ХАНГАЛТЫН АЛБАНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ,  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

2020 оны 10 дугаар сарын 23

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр баталсан Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 25/20 дугаар удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны аудитор П.Цогбаяр, А.Мөнх-Эрдэнэ, Т.Саранчимэг, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Оюут нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийг дуусталх хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, цалин хөлсний бүртгэл тооцоо зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Албан томилолтын зардлыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасан “Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт”-гүйгээр албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцсон.

ГТҮШХА нь 2019 он, 2020 оны батлагдсан төсвөөр гүйцэтгэсэн худалдан авах үйл ажиллагаанд Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 363 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллаагүй, худалдан авалтаа төлөвлөж, тайлагнаагүй.

“Петростар” ХХК-тай сонгон шалгаруулалтгүйгээр худалдан авалт хийсэн. “Петростар” ХХК-тай 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан “Шатахууны картын үйлчилгээ үзүүлэх” №17/05/01 дугаартай гэрээ нь “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын шаардлагыг хангаагүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу ГТҮШХА нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудсанд /tender.gov.mn/ бүртгэгдээгүй, мөн тус хуулийн 8.5-д заасныг зөрчиж төсөвт өртгийг хэд хэд хувааж шууд худалдан авалт хийсэн.

Тус албаны 6 жолоочийн жолоодох эрхийн үнэмлэхний хугацаа дууссан, 11 жолооч олон удаа зөрчил гаргаж Замын цагдаагийн газраас зөрчлийн бүртгэлийн оноогоо хасуулж өнөөдрийн байдлаар 1-3 оноотой болсон байна. Нэг жолооч Зөрчлийн тухай хуулийн 14.7.3.1 заалтын дагуу 1 жилийн хугацаатай жолоодох эрх нь хасагдсан байна. Жолооч нарын эрхэлсэн ажилдаа гаргаж байгаа алдаа зөрчлийг байнга хянаж, зөрчил гаргасан байдлын шалтгаан нөхцөлд дүгнэлт хийж, засаж залруулах цаашид гаргахгүй байх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй.

2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар ГТҮШХА-нд бүртгэлтэй нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглагддаг 68 тээврийн хэрэгсэлтэй холбоотой нийт 263 удаагийн зөрчилд торгууль ногдуулсан нь төлөгдөөгүй.

Нас барсан ажилтны хөдөлмөрийн гэрээг нас барсан өдрөөс хойш 4-5 өдрийн дараа дуусгавар болгож тушаал гаргасан байгаагаас хөдөлмөр цалин хөлсний тооцоонд алдаа гарах, ажиллаагүй хүнд цалин хөлс олгох, өр авлага үүсэхэд хүргэсэн байна.

Нягтлан бодогч албаны даргын гаргасан тушаалын утгыг буруу ойлгосноор 3 ажилтанд хүндэтгэн үзэх шалтгаанаар ажилдаа ирээгүй үеийн олговор, цагийн балансыг буруу гаргаснаас уалин хөлс тус тус илүү олгогджээ.

Тооцооны нягтлан бодогч ажилтнуудын удаан жил ажилласны нэмэгдэл хөлсний тооцооллыг хийхдээ алдаатай хийж байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дах заалтыг зөрчиж 6 ажилтанд цалинтай чөлөө олгохдоо хоолны мөнгийг хасаж олгосон зөрчил байна. Мөн 2020 оны 04 дүгээр сараас цалинтай чөлөө олгохгүй байх, зайлшгүй шаардлагатай тохиолдолд ээлжийн амралтаас хасч тооцох гэсэн ИНЕГ-аас өгсөн үүрэг даалгаврыг зөрчиж 4 ажилтанд цалинтай чөлөө олгосон.

ГТҮШХА-нд “Албан тушаалын тодорхойлолт”-ын зарим шаардлагыг хангаагүй 12 ажилтан ажиллаж байна.

ГТҮШХА-ны даргын 2020 онд гаргасан тушаалуудад боловсруулсан ажилтан гарын үсэг зураагүй байгаа нь Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 68 дугаар тушаалаар баталсан “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн MNS 5140:2011 стандарт, “Баримт бичиг боловсруулсан тухай тэмдэглэлийн бүрдэл”-ийг хангаж ажиллаагүй.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1-д “...Бичгээр гаргасан өргөдөл, гомдолд овог, нэр оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсгээ зурна. Хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зурж болно...” гэсэн заалтыг зөрчиж Агаарын хөлгийн газрын үйлчилгээний хэлтсийн дарга нь хэлтсийн ажилтнуудын өмнөөс өргөдөл бичсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг цаг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд оруулахдаа цөөн тооны мэдээллийг оруулаагүй орхисон.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг арилгах, залруулах талаар тус албанд 19 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА